

УДИРДАМЖ

ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ХАМТДАА 2021

ЗҮҮН АЗИЙН БҮСИЙН ХЭМЖЭЭНД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СЭДВЭЭР СУРАГЧДЫН ДУНД ЗАРЛАЖ БУЙ УРАЛДААН



ХАМТДАА ОРОЛЦОЦГООЁ!

Өнгөрсөн жилд зохион байгуулагдсан төсөлт уралдаан маш том амжилт авчирсан бөгөөд энэхүү амжилтыг үргэлжлүүлэн 2021 онд Гёте-Институтуудээс дахин зарлагдаж буй “Ирээдүйн төлөө хамтдаа” сурагчдын уралдаанд та бүхнийг оролцохыг урьж байна. Манай уралдааны сэдэв нь НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилгуудад тулгуурладаг билээ. 2021 онд бид дараах зорилгуудыг үндсэн сэдвээрээ сонголоо. Үүнд: **ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ** болон **ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ**.

ТА НАР ЮУ ХИЙХ ЁСТОЙ ВЭ?

Уралдааны хүрээнд та нар хотдоо, гудамж талбайд, сургуульдаа нөхцөл байдал ямар байгааг судалж, өөрсдийн санаа, үйл хэргээрээ тулгамдаж буй асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах хэрэгтэй.

ХЭН ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ВЭ?

Уралдаанд БНХАУ, Хонг Конг, Япон, Монгол, Өмнөд Солонгос, Тайвань улсуудын **Багш-Сурагчдын баг** оролцох боломжтой. Хамгийн шилдэг төслийн багуудыг **2021 оны 9 дүгээр сарын 4-нөөс 5-ны** хооронд зохион байгуулагдах **Олон улсын залуу элч төлөөлөгчдийн хоёрдугаар бага хуралд** урьж оролцуулах болно. Том том шагналууд ч бас та нарыг хүлээж байна!

Сонгон шалгаруулах явц

Багууд төслийн эхний санаагаа 4 дүгээр сарын 30-ныг хүртэл өөрийн орон дахь Гёте-Институтэд ирүүлнэ. Төслийн санааг хүлээж авах хүн: Б. Бэрцэцэг, Bertsetseg.Bumaakhuu@goethe.de

Хараат бус шүүгчдийн бүрэлдэхүүн ирүүлсэн бүх төслөөс 18 хүртэлх төслийн багийг эхний ээлжинд сонгон шалгаруулна. Эдгээр сонгогдсон төслийн багуудад төслөө цаашид хэрэгжүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна мэргэжлийн хүн дасгалжуулан дагалдах болно.

2021 оны 9 дүгээр сарын 4-нөөс 5-ны хооронд зохион байгуулагдах **Олон улсын залуу элч төлөөлөгчдийн хоёрдугаар бага хуралд** төслийн багууд өөрсдийн төслөө герман хэл дээр танилцуулах бөгөөд эцэст нь өндөр түвшний мэргэжилтнүүдээс бүрдсэн шүүгчид **ялагч төслийг** тодруулах болно.

Шүүгчдийн бүрэлдэхүүн дараах **шалгуураар** ирүүлсэн төслүүдийг үнэлнэ. Үүнд:

- Сурагчдад болоод тэдний шууд орчин тойронд гарах ач холбогдол, цаг үетэйгээ нийцсэн байдал
- Төслийн танилцуулгын тодорхой байдал, логик, бүтэц
- Хэрэгжүүлсэн төслийн амьдралд ойр байдал, үр дүнд чиглэгдсэн байдал
- Төслийг баримтжуулсан байдал, түүний хэрэгжүүлэлт

Оролцох үндсэн нөхцөл

1. Төслийн баг **3 сурагч, 1 багшаас** бүрдэнэ.
2. **2021 оны 4-р сарын 30-ныг** хүртэл төслийн баг дараах сэдвүүдийн аль нэгээр төсөл хүргүүлнэ. Үүнд:

ӨЛСГӨЛӨНГ ЗОГСООХ ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ

3. Та нар өөрсдөө болон оролцсон багш нар **2021 оны 9 дүгээр сарын 4, 5-ны** өдрүүдэд зохион байгуулагдах Олон улсын залуу элч төлөөлөгчдийн хоёрдугаар бага хуралд оролцох боломжтой байх.
4. Та нар **7-11-р ангид** суралцдаг хамгийн багадаа **герман хэлний А1 түвшинг** дүүргэсэн байх.
5. Төслийн баг **герман хэл дээр** төслөө танилцуулахад бэлэн байх (кино, театрын жүжиг гэх мэт өөр хэлбэрээр танилцуулсан ч болно) Бүтээлч байдалд чинь хязгаар тавиагүйг санаарай!
6. Сургуулийн удирдлага та нарын уралдаанд оролцохыг дэмжих.

Уралдаанд ирүүлэх материал

1. Бүрэн гүйцэд бөглөсөн анкет
2. Герман хэл дээр бичсэн төслийн танилцуулга
3. Сурагчдад зориулсан зөвшөөрлийн бичиг (эцэг эх, асран хамгаалагчид бөглөнө)
4. Багш нарт зориулсан зөвшөөрлийн бичиг

→эдгээр анкетуудыг веб хуудаснаас татаж авна уу

Үүнээс гадна:

5. Шаардлагатай хэлний мэдлэгийг батлах баталгаа (хэлний түвшингийн сертификат эсвэл герман хэлний багшийн тодорхойлолт)

Уралдааны материал хүлээн авах эцсийн хугацаа

2021 оны 4-р сарын 30-ныг хүртэл уралдааны материалаа хатагтай Б. Бэрцэцэгт дараах хаягаар ирүүлнэ үү: Bertsetseg.Bumaakhuu@goethe.de

Өнгөрсөн жилийн уралдааны тухай баримтат видеог та нар эндээс үзэж болно:

<https://www.youtube.com/watch?v=3ECmTFCqDcw&feature=youtu.be>

УРАЛДААНД ИДЭВХИТЭЙ ОРОЛЦОНО ГЭДЭГТ ИТГЭЖ БАЙНА!